

**ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН 2024 ОНЫ ТАЙЛАН**

2024.11.18

| №  | Арга хэмжээ  | Шалгуур             | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хэрэгжилт   | Үнэлгээ |
|--|--|---------------------|--------------|--------------|---|---------|
| <b>НЭГ. ЗОРИЛТ -1 БАГШ АЖИЛТНЫ ЦАЛИН ХӨЛС, ШАГНАЛ УРАМШУУЛЛЫН ТОГТОЛЦООГ ХЭРЭГЖҮҮЛЭХ</b> |  |                     |              |              |   |         |
| 1.   | Албан хаагчдад олгох хоол унааны нэмэгдлийг батлагдсан төсвийн дагуу олгох | Албан хаагчдын тоо  | 70           | 79           | 2024 оны 11 сарын 15-ны байдлаар 79 багш, ажилтнуудад сар бүр унаа, хоолны мөнгө бодож 57,666,00 төгрөгний нэмэгдлийг цалин сангаас олгож нийгмийн баталгааг дэмжин ажилласан.<br><b>Хүрсэн түвшин:</b> 79 багш, ажилтанд 57,666,00 төгрөгний унаа, хоолны мөнгө олгосон.<br><b>Хэрэгжилтийн хувь:</b> 100%   | 100     |
| 2.   | Албан хаагчдад ур чадварын нэмэгдэл төсөвт багтаан олгох                   | Албан хаагчдын тоо  | 40           | 41           | Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журмын дагуу сургуулийн захирлын тушаалаар сар бүр багш, ажилчдын ажлыг сургалтын алба, захиргаа аж ахуйн албаны менежер нар дүгнэн 12 багш, 31 ажилчдад 82,119,612 төгрөгний ур чадварын нэмэгдэл олгосон.<br><b>Хүрсэн түвшин:</b> нийт 43 багш, ажилтанд 82,119,612 төгрөгний ур чадварын нэмэгдэл олгосон.<br><b>Хэрэгжилтийн хувь:</b> 100% | 100     |
| 3.   | Улирал бүр үр дүнгийн урамшуулал олгох                                     | 100% олгосон байна. | 100%         | 100%         | 2024 оны 11 сарын 15-ны өдрийн байдлаар багш, ажилчдын гүйцэтгэлийн ажлыг 1,2,3 дугаар улиралд дүгнэн 79 багш,ажилчдад 79,641,165 төгрөгний үр дүнгийн урамшуулал олгож нийгмийн баталгааг дэмжсэн.<br><b>Хүрсэн түвшин:</b> 79 багш, ажилтанд 79,641,165 төгрөгний үр дүнгийн урамшуулал олгосон.<br><b>Хэрэгжилтийн хувь:</b> 100%  | 100     |
| 4.   | Багшлах зэргийн нэмэгдэл сар бүр олгох                                     | Багшийн тоо         | 27           | 27           | Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн хүрээнд 2024 оны 11 дүгээр сарын 18-ны байдлаар багшлах зэргийн нэмэгдлийг төсөвт тусган 38 багшид 39,810,118 төгрөгний зэргийн нэмэгдэл олгож нийгмийн баталгааг хангаж, еерийгөө хөгжүүлэх боломжийг нь нэмэгдүүлсэн.<br><b>Хүрсэн түвшин:</b> 38 багшид 39,810,118 төгрөгний   | 100     |

|    |   |                          |      |      |   |     |
|----|---|--------------------------|------|------|---|-----|
|    |   |                          |      |      | нэмэгдэл олгосон.<br><b>Хэрэгжилтийн хувь:100%</b>  |     |
| 5. | Орон нутгийн нэмэгдэл болон төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл сар бүр олгох   | Албан хаагчийн тоо       | 79   | 79   | Хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажилласан болон төрийн албанд удаан жил ажилласан хугацааны нэмэгдлийг төсөвт тусган 2024 оны 11 сарын 15-ны өдрийн байдлаар 79 багш, ажилтан нарт сар бүр бодож 116,108,865 төгрөгний нэмэгдэл олгож төрийн албанд тогтвортой ажиллах нийгмийн асуудлыг шийдвэрлэн ажилласан.<br><b>Хүрсэн түвшин:</b> 79 багшид 116,108,865 төгрөгний нэмэгдэл олгосон.<br><b>Хэрэгжилтийн хувь:100%</b> | 100 |
| 6. | Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16,1,2 дахь заалтын дагуу багшид 5 жил тутамд мөнгөн тэтгэмж олгох | Албан хаагчдын тоо       | 5    | 13   | 2024 оны 11 дүгээр сарын байдлаар 10 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг 13 багшид 136,437,000 төгрөгний 1 удаагийн тэтгэмж олгосон.<br><b>Хүрсэн түвшин:</b> 5 жилийн мөнгөн тэтгэмжийг 15 багшид 136,437,000 төгрөгний тэтгэмж олгосон.<br><b>Хэрэгжилтийн хувь:100%</b>   | 100 |
| 7. | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан ажилтанд хуулийн дагуу 5 жил тутамд мөнгөн тэтгэмж олгох  | Албан хаагчдын тоо       | 0    | 2    | 2024 оны 11 дүгээр сарын байдлаар 10 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг 2 ажилтанд 13,962,000 төгрөгний 1 удаагийн тэтгэмж олгосон.<br><b>Хүрсэн түвшин:</b> 5 жилийн мөнгөн тэтгэмжийг 2 ажилтанд 13,962,000 төгрөгний тэтгэмж олгосон.<br><b>Хэрэгжилтийн хувь:100%</b>   | 100 |
| 8. | Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 5 дугаар зүйлийн 5.5 заасан тохиолдолд цалинтай чөлөө олгох  | 100% хэрэгжүүлсэн байна. | 100% | 100% | 2024 онд байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 5 дугаар зүйлийн 5.5 заалтын дагуу багш, ажилчдын өргөдлийг үндэслэн 1-8 хоногийн дотор цалинтай чөлөө олгох асуудлыг 100% хэрэгжүүлж ажилласан.<br><b>Хүрсэн түвшин:</b> Багш ажилчдын өргөдлийг үндэслэн хөдөлмөрийн дотоод журмын дагуу 100% цалинтай чөлөө олгосон.<br><b>Хэрэгжилтийн хувь:100%</b>  | 100 |
| 9. | Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 6 дугаар зүйлд тусгагдсан шагнал, урамшуулал, 1 удаагийн тэтгэмж олгох                                       | Албан хаагчдын тоо       | 5    | 5    | 2024 онд хөдөлмөрийн дотоод журамд тусгагдсан дагуу шагнал урамшуулалын 1 удаагийн тэтгэмжид 18 багш ажилчдад 4,000,000 төгрөг, амаржиж хүүхэдтэй болсон 2 ажилтанд 100,000 төгрөг, Үндсэн ажилтны гэр бүл, садан төрөл нас   | 100 |



|   |  |                        |    |    |  |     |
|---|--|------------------------|----|----|--|-----|
|   |  |                        |    |    | <p>барсан 8 багш ажилтанд 2,400,000 төгрөг, үндсэн ажилтан нас барсан 1 ажилтанд 1,000,000 төгрөг буюу нийт 29 багш ажилчдад 6,500,000 төгрөгний буцалтгүй тусламж олгож нийгмийн асуудлыг дэмжиж ажилласан. Мөн ҮЭ-ийн хураамжаас "Дархлаажуулалтын аян"д 830 000, багш ажилчдын 159 хүүхдийн бэлгэнд 1 600 000, Дорнод аймагт болсон тэмцээний зардалд-400,000 төгрөгний дэмжлэг албан хаагчдад үзүүлсэн.</p> <p><b>Хүрсэн түвшин:</b> 29 багш ажилчдад 6,500,000, ҮЭ-ээс 2,830,000 төгрөгний 1 удаагийн буцалтгүй тусламж, тэтгэмж олгож нийгмийн асуудлыг дэмжиж ажилласан.</p> <p><b>Хэрэгжилтийн хувь:</b>100%</p> |     |
| <b>ХОЁР. ЗОРИЛТ-2. АЖИЛТНЫ АЖЛЫН БАЙРНЫ ХЭВИЙН НӨХЦЛИЙГ БҮРДҮҮЛЭХ</b> |  |                        |    |    |  |     |
| 1.  | Багш , ажилчдаас сэтгэл ханамжийн судалгаа авах, нэгтгэх, холбогдох албан тушаалтанд танилцуулах | Санал асуулга авах тоо | 1  | 1  | <p>2024 оны 10 дугаар сарын 16-ны өдөр 57 багш ажилчдаас сэтгэл ханамжийн судалгаа авч нэгтгэн сургуулийн захиралд танилцуулан 3 сургалтыг зохион байгуулж, вэбсайтад санхүүгийн холбогдох мэдээллийг оруулах, самбарт байршуулах зэрэг ажлуудыг хэрэгжүүлсэн. Мөн шаардлагатай тоног төхөөрөмжийг 2025 оны төлөвлөлтөнд оруулан шийдвэрлэсэн.</p> <p><b>Хүрсэн түвшин:</b> Судалгааг 1 удаа явуулж 57 багш ажилчдыг хамруулан, холбогдох саналуудыг төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлсэн.</p> <p><b>Хэрэгжилтийн хувь:</b>100%</p>  | 100 |
| 2.  | Албан хаагчдын хувийн хэргийн бүрдүүлэх, шинэчлэх баяжилт хийх                                   | Албан хаагчдын тоо     | 80 | 80 | <p>2024 оны 31 ажилтан, 49 багшийн хувийн хэргийг төрийн албан зөвлөлийн 2022 оны 600 дугаар тогтоолын дагуу хувийн хэргийн бүрдүүлэлтийг хийж, хувийн хэрэгт баяжуулалт хийж ажилласан.</p> <p><b>Хүрсэн түвшин:</b> 80 багш, ажилчдын хувийн хэргийн шинэчлэн бүрдүүлж, 2024 оны баяжуулалтыг хийсэн.</p> <p><b>Хэрэгжилтийн хувь:</b>100%</p>   | 100 |
| 3.  | Шинээр орсон албан хаагчдын мэдээллийг хүний нөөцийн удирдлагын системд оруулах                  | Албан хаагчдын тоо     | 1  | 2  | <p>2024 онд шинээр ажилд орсон А.Ундармаа, Б.Мөнхсолонго, Д.Амарсанаа, Б.Алтанчимэг, Г.Цэрэндэлгэр, Н.Гантогтох, Б.Нармандах нарын 7 ажилтны мэдээллийг хүний нөөцийн удирдлагын</p>   | 100 |

|    |  |                           |   |    |  |     |
|----|--|---------------------------|---|----|--|-----|
|    |  |                           |   |    | <p>системд оруулсан.<br/> <b>Хүрсэн түвшин:</b> Шинээр ажилд орсон 7-н албан хаагчийн мэдээллийг хүний нөөцийн удирдлагын системд бүрэн оруулсан.<br/> <b>Хэрэгжилтийн хувь:</b> 100%</p>  |     |
| 4. | Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн санд дутуу мэдээллийг гүйцэд болгон шинэчлэх, баяжилт хийх | Албан хаагчдын тоо        | 0 | 10 | <p>2024 оны 11 сарын 15-ны өдрийн байдлаар 80 багш ажилтны мэдээллийг хүний нөөцийн удирдлагын мэдээллийн системд бүрэн оруулж, шинээр ажилд орсон 10 багш, ажилтны мэдээллийг бүрэн оруулсан. Мөн дотоод хөдөлгөөн хийгдсэн 2 багш, 2 ажилтны мэдээллийг шинэчилсэн.<br/> <b>Хүрсэн түвшин:</b> Хүний нөөцийн удирдлагын системд шинээр 10 ажилтан, дотоод хөдөлгөөн хийгдсэн 4 ажилтангийн мэдээллийг бүрэн шинэчлэн оруулсан.<br/> <b>Хэрэгжилтийн хувь:</b> 100%</p>   | 100 |
| 5. | Сул орон тоог зарлах хүний нөөцийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах                            | Зарлах тоо                | 1 | 1  | <p>Сургуулийн хүний нөөцийн судалгаа, ажлын байрны судалгааг гарган сул орон тоог нөхөх, бүрдүүлэх ажлыг аймгийн цахим зарын сайт, сургуулийн вэбсайтад байршуулсан, аймгийн ХХҮГазрын хөдөлмөр эрхлэлтийн хэлтэст 5 удаа зар өгч иргэдэд зарын мэдээлэл хүргүүлснээр 8-н ажлын байранд сул орон тоог бууруулж, 8-н иргэн ажилд авч хүний нөөцийг бүрдүүлсэн. Мөн 8 хүнийг ажлын байраар хангасан.<br/> <b>Хүрсэн түвшин:</b> Сул орон тоог 5 удаа зарлан 8 ажлын байрын нөөцийг бүрдүүлсэн.<br/> <b>Хэрэгжилтийн хувь:</b> 100%</p> | 100 |
| 6. | Хүний нөөцийн ил тод байдлыг ханган самбарт холбогдох мэдээллийг байршуулах                    | Байршуулах мэдээллийн тоо | 4 | 4  | <p>Нийтийн мэдээллийн ил тод байдлын хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор хүний нөөцийн ил тод байдлын самбарт бүтэц орон тоо батлах тушаал, хүний нөөцийн сул орон тооны мэдээлэл, хөдөлмөрийн дотоод журам болон бусад холбогдох мэдээллийг байршуулсан. Сургуулийн цахим вэбсайтад 5 мэдээллийг байршуулж иргэдэд мэдээлэл өгч ил тод байдлыг хангаж ажилласан.<br/> <b>Хүрсэн түвшин:</b> Хүний нөөцийн мэдээллийг самбарт болон цахим сайтад 5 удаа байршуулсан.<br/> <b>Хэрэгжилтийн хувь:</b> 100%</p>                       | 100 |
| 7. | Тоон гарын үсэг аваагүй албан хаагчдын   | Арга                      | 1 | 1  | <p>2024 оны 10 дугаар сарын 28-ны өдөр багш,</p>   | 100 |



|  |   |                    |    |    |   |     |
|--|---|--------------------|----|----|---|-----|
|  | судалгаа гарган тоон гарын үсэгтэй болгох ажлыг зохион байгуулах                    | хэмжээний тоо      |    |    | ажилчдаас тоон гарын үсэг авсан болон аваагүй албан хаагчдын судалгаа гаргасан. Тоон гарын үсэг олгох ажлыг сургууль дээр Аймгийн УБХэлтэстэй хамтран зохион байгуулж, тоон гарын үсэг аваагүй байсан 12 албан хаагчдыг тоон гарын үсэгтэй болгосон.<br><b>Хүрсэн түвшин:</b> Тоон гарын үсэгтэй болгох ажлыг 1 удаа зохион байгуулж, шинээр 12 багш ажилчдыг тоон гарын үсэгтэй болгосон.<br><b>Хэрэгжилтийн хувь:</b> 100%  |     |
| 8.   | Хүний нөөц, архивын ажилтнуудын ажлын өрөөг засварлах, ажиллах нөхцлийг сайжруулах  | Өрөөний тоо        | -  | 1  | Хүний нөөц, архивын ажилтнуудын ажлын өрөөг засварлах ажлыг 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр замаск түрхэх, мөөгөнцрийг арилгах, обой наах зэрэг ажлын өрөөг хэсэгчлэн засварлан ажилтны ажиллах нөхцлийг сайжруулсан.<br><b>Хүрсэн түвшин:</b> Хэсэгчлэн засвар хийж ажилтны ажиллах нөхцлийг сайжруулсан.<br><b>Хэрэгжилтийн хувь:</b> 100%  | 100 |
| <b>ГУРАВ. БАГШ, АЖИЛТНЫ НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ, ЭРҮҮЛ МЭНДИЙГ ХАМГААЛАХ</b> |   |                    |    |    |   |     |
| 1.   | Монголын ахмадын баярын өдөр байгууллагын харъяалалтай ахмадуудад хүндэтгэл үзүүлэх | Арга хэмжээний тоо | 1  | 1  | 2024 оны 10 дугаар сарын 01-ны өдөр Монголын Ахмадын баярын өдрийг тохиолдуулан байгууллагаас өндөр насны тэтгэвэрт гарсан харъяалалтай 9 багш, 6 ажилтан ахмадуудыг хүлээн авч ахмадын сангаас 5,900,000 төгрөгний санхүүжилтээр гарын бэлэг дурсгалын зүйл өгч хүндэтгэл үзүүлэн нийгмийн баталгааг дэмжиж ажилласан.<br><b>Хүрсэн түвшин:</b> Хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг 1 удаа зохион байгуулж, 5,900,000 төгрөгний бэлэг дурсгалын зүйл өгсөн.<br><b>Хэрэгжилтийн хувь:</b> 100% | 100 |
| 2.   | Нийтийн үйлчилгээний ажилчдын баяр тэмдэглэх арга хэмжээ зохион байгуулах           | Арга хэмжээний тоо | 1  | 1  | 2024 оны 10 дугаар сарын 25-26 ны өдрүүдэд Хятад улсын Эрээн хотын хөгжилтэй танилцах, албан хаагчдыг идэвхжүүлэх аялалын арга хэмжээг зохион байгуулж 24 албан хаагчид хамрагдсан.<br><b>Хүрсэн түвшин:</b> Аялал 1 удаа зохион байгуулж 24 албан хаагч хамруулсан.<br><b>Хэрэгжилтийн хувь:</b> 100%  | 100 |
| 3.   | Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд албан хаагчдыг байр орон сууцанд амьдрахад         | Албан хаагчдын тоо | 30 | 31 | Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд хүний нөөцийг тогтвор сууришилтай ажиллуулах зорилгоор 31  | 100 |

|    |   |                        |      |      |  |     |
|----|---|------------------------|------|------|--|-----|
|    | дэмжлэг үзүүлэх   |                        |      |      | багш, ажилтнуудыг сургуулийн байранд оруулж, орон сууцанд амьдрах нийгмийн асуудлыг дэмжин ажилласан.<br><b>Хүрсэн түвшин:</b> 31 багш ажилтанд орон сууцанд амьдрахад дэмжлэг үзүүлсэн.<br><b>Хэрэгжилтийн хувь:</b> 100%   |     |
| 4. | Албан хаагчдыг эрт илрүүлгийн үзлэг, оношлогоонд хамруулах ажлыг зохион байгуулах | Албан хаагчдын тоо     | 40   | 40   | Албан хаагчдыг эрт илрүүлгийн үзлэг, оношлогоонд хамруулахаар төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн төлөвлөгөөнд тусгасан боловч Боловсролын Яамнаас 2024 оны төсөв тусгагдаагүй тул 2025 онд хийхээр шийдвэрлэсэн. эрт илрүүлгийн үзлэг, оношлогоонд хамруулахаар ажилчдын судалгааг гаргасан.<br><b>Хүрсэн түвшин:</b> 2025 онд дахин төлөвлөхөөр шийдвэрлэсэн.<br>Хэрэгжилтийн хувь:30 %.   | 30  |
| 5. | Албан хаагчдын дунд “ Спортын өдөр-7 хоног ” арга хэмжээ зохион байгуулах         | Арга хэмжээний тоо     | -    | 5    | Сургуулийн багш ажилчдыг баг болгон хувааж албан хаагчдын дунд “ Спортын өдөр-7 хоног ” арга хэмжээг 4 удаа зохион байгуулсан. Уг спортын өдөрлөгийг арга хэмжээнд баг тус бүр нэг спортын төрлийн тэмцээн явуулан хаагчдын эрүүл мэнд, бие бялдрын хөгжил сайжирч, хамт олныг идэвхжүүлж, Түмэн дасгал хөдөлгөөнийг зааж сургасан.<br><b>Хүрсэн түвшин:</b> Спортын арга хэмжээг 4 удаа зохион байгуулж, албан хаагчдад Түмэн дасгалыг зааж сургасан.<br><b>Хэрэгжилтийн хувь:</b> 100% | 100 |
| 6. | Ажлын байранд хувийн хамгаалах хэрэгсэл, дүрэмт хувцас өмсгөх, хэвшүүлэх          | 100% хэвшүүлсэн байна. | 100% | 100% | Оюутан суралцагч нарт галын аюулгүй ажиллагаа, тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа, даралтат сав, хувийн хамгаалах хэрэгсэлийн талаар анхан шатны мэдлэг арга зүйн талаар харилцан, туршлага солилцох, тэднийг хөгжүүлэх, мэдээлэл өгөх, холбогдох хууль тогтоомж, хэрэглэх аргачлалыг таниулах зорилгоор сургалтыг 1 удаа явуулсан.<br>Шинээр элсэн орсон 126 суралцагчийг хувийн хамгаалах хэрэгслээр, шаардлагатай 12 ажилчдад хувийн хамгаалах хэрэгслийг олгосон.                  | 100 |

|    |   |                  |   |   |  |     |
|----|---|------------------|---|---|--|-----|
|    |   |                  |   |   | <p>Суралцагчид болон мэргэжлийн багш нар дадлага хичээл, лабораторид хичээллэх бүрдээ хөдөлмөр хамгааллын хувцасыг / каск, хантааж, хамгаалалтын шил гэх мэт/ бүрэн өмсөж хичээллэдэг. ХАБЭА-ын ажилтан өдөр бүр хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч, хяналт тавьж дүрэмт хувцас, хамгаалах хэрэгсэл өмсгөж хэвшүүлсэн.</p> <p><b>Хүрсэн түвшин:</b> 126 Суралцагч оюутан, 12 ажилчдыг хувийн хамгаалах хэрэгсэл, дүрэмт хувцасаар ханган, ажлын байранд өмсгөж хэвшүүлсэн.</p> <p><b>Хэрэгжилтийн хувь:</b> 100%</p>   |     |
| 7. | Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлд үзлэг шалгалт хийх | Шалгалт хийх тоо | 1 | 2 | <p>Ажил эхлэхийн өмнө мэргэжлийн багш нар, цахилгаанчин, мужаан, сантехникч, гал тогооны ажилчдад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгааг өдөр бүр өгч, хөдөлмөрийн техник, нөхцөлд 12 удаа үзлэг шалгалт хийж зөвлөмж хүргүүлэн, нэн даруй хариу арга хэмжээ авч ажилладаг. Мөн сар бүр техник ашиглалтын паспортыг хөтлүүлэн, хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна. 2024 онд 83 багш, ажилтан болон 1,2,3-р курсын нийт 632 суралцагчдыг "Мөнх даатгал"-ын "Гэнэтийн ослын даатгал"-д гэрээ хийн даатгалд 100 хувь хамруулсан.</p> <p><b>Хүрсэн түвшин:</b> хяналт шалгалт 12 удаа хийж, гэнэтийн ослын даатгалд 83 багш, ажилтан, 632 оюутан суралцагч хамруулсан.</p> <p><b>Хэрэгжилтийн хувь:</b> 100%</p> | 100 |

Тайлан гаргасан: Хүний нөөц, гадаад харилцаа хариуцсан ажилтан  А.Ундармаа

Хянасан: Захирал  Ш.Отгонжаргал

